



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



БИЧИЛ САНХҮҮГИЙН
ХӨГЖЛИЙН САН

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ ТАН АА

Улаанбаатар хот
2018

ӨМНӨХ ҮГ

Олон улсын хэмжээний санхүүгийн үйл ажиллагаа нэмэгдэхийн хэрээр санал болгож буй санхүүгийн үйлчилгээ нэмэгдэж, санхүүгийн хямрал тохиовол зөвхөн нэг улс бус бүс нутгийг хамрах хандлагатай байна. Санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбогдуулан бодлого боловсруулагчдын түвшинд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг анхаарах талаар илүү эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү хандлага нь олон улсын бодлогын хэмжээний баримт бичигт тусгагдах болсон. Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал хүчин зүйл юм.

Монгол Улсын санхүүгийн салбарын зонхилох хэсгийг банкны салбар бүрдүүлдэг: тус салбар нь нийт санхүүгийн зах зээлийн ойролцоогоор 95%-ийг бүрдүүлдэг. Банкны үйлчилгээ Монгол Улсын нийт хүн амын нэлээдгүй хэсэгт хүрээд байгаа бол даатгал, хөрөнгө оруулалт, үнэт цаас болон санхүүгийн бусад үйлчилгээний нэвтрэлт төдийлөн хангалтгүй бага хэрэглэгдэж байна.

2012 онд Дэлхийн банк манай улсад Санхүүгийн боловсрол, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж буй байдлын судалгааг хийгээд “Хангалтгүй байна, сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтэд хүрсэн. Банкны салбарт хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал хүн амын томоохон хэсэгт улам бүр хамааралтай болж байгааг санхүүгийн бодлого боловсруулагчид болох Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо онцлон үзэж санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн бодлогын баримт бичигтэй болохоор зорьж ажиллаж байна.

Монголбанкны санаачлагаар анх удаа санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах чиглэлээр хэрэгжих аяныг 2018 оны 1 дүгээр сараас зарлан энэхүү аян нь нийт санхүүгийн салбарыг хамарч байгаа бөгөөд гол зорилго нь санхүүгийн хэрэглэгч болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын эрх тэгш харилцах чадамжийг бэхжүүлж, уг харилцаанд оролцогч этгээдүүдийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалтын байгууллагын үүрэг, эрсдэлд суурилсан шалгуур стандартыг боловсронгуй болгох зэрэгт оршино. Иймд энэхүү гарын авлагаас санхүүгийн хэрэглэгч Та өөрт хэрэгтэй мэдлэг, мэдээллийг олж авна гэдэгт бид найдаж байна.

1. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ БА САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Санхүүгийн хэрэглэгч гэж санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвхөн өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан авч буй хувь хүнийг хэлдэг. Зарим улсад жижиг болон бичил аж ахуйн нэгжийг хамруулах тохиолдол байдаг.



Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч гэж бусдаас таган төвлөрүүлсэн хөрөнгөөр өргөн хүрээтэй санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн төлөө байгууллагыг хэлдэг. Тухайлбал, банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани, үнэт цаасны арилжаа эрхлэгч, хөрөнгө оруулалтын сан зэрэг болно.



2. САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ИНСТИТУЦИЙН БОЛОН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН

Банкны үйлчилгээнд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах одоогийн институт, хууль, эрх зүйн орчинг Монгол Улсын дараах хууль тогтоомжуудаар тодорхойлж байна:

- ✓ Үндсэн хууль
- ✓ Иргэний хууль
- ✓ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль
- ✓ Зар сурталчилгааны тухай хууль
- ✓ Өрсөлдөөний тухай хууль
- ✓ Банкны тухай хууль
- ✓ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (“БЭБХЭМХТТЗҮА-ны тухай хууль”)
- ✓ Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль

Монгол Улсын санхүүгийн зах зээлд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх институцын чиг үүргийг төрийн захиргааны дараах гурван байгууллага хүлээн ажиллаж байна. Эдгээр нь:

- ✓ Монголбанк (“МБ”);
- ✓ Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”);
- ✓ Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (“ШӨХТГ”).

Дээр дурдсан гурван байгууллагаас гадна Сангийн яам (“СЯ”) санхүүгийн зах зээлийг зохицуулах хууль, эрх зүйн актуудыг боловсруулан батлуулахаар Монгол Улсын Их Хуралд өргөн барих үүргийг хүлээдэг. Мөн СЯ нь санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд ерөнхий хяналтыг тавьж ажиллана.

Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг Хадгаламжийн даатгалын корпораци хамгаалж ажилладаг.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Монголбанк нь банкны салбарт зохицуулалт, хяналт тавьж ажилладаг.



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

Санхүүгийн зохицуулах хороо нь даатгал, үнэт цаас, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг байгууллагын харилцагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.



Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр бүх салбарын хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцаж ажилладаг.



**ХАДГАЛАМЖИЙН
ДААТГАЛЫН
КОРПОРАЦИ**
Deposit Insurance Corporation of Mongolia

Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой байгууллага.

3. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД



Худалдаа, маркетингийн асуудал

- ✓ Худал, төөрөгдүүлсэн зар сурталчилгаа
- ✓ Дайрч давшилсан байгууллагын маркетинг
- ✓ Хэрэглэгчийн хүсээгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- ✓ Хэрэглэгчийн урьдаас таамаглаагүй шимтгэл, төлбөр, хураамж

СҮҮ байгууллага санхүүгийн мэдээллийг нээлттэй мэдээлэхтэй холбоотой асуудал

- ✓ Хууль, дүрэм журмыг биелүүлэхгүй байх
- ✓ Хэрэглэгчийн үүргийг таниулахгүй байх

Өр барагдуулахтай холбоотой асуудал

- ✓ Дарамт, шахалт үзүүлэх,
- ✓ Данснаас урьдчилан мэдэгдэлгүй мөнгө татах

Хүү, шимтгэл, хураамжтай холбоотой асуудал

- ✓ Зээлийн өндөр хүү
- ✓ Далд хүү
- ✓ Хэт өндөр алданги тооцолт

Мэдээллийн ил тод байдалтай холбоотой асуудал

- ✓ Хэрэглэгчийг хэрэгтэй мэдээллээр бүрэн хангахгүй байх эсхүл дутуу тайлбарлах
- ✓ Ойлгомжгүй, мэргэжлийн үг хэллэгээр мэдээлэл өгөх

4. ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ САНХҮҮГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Санхүүгийн байгууллагуудтай харьцахад та тодорхой эрх, үүрэгтэй байна. Иймд та өөрийн эрх, үүргийг ойлгож, эрх зөрчигдсөн үед эрхээ хамгаалах, өөрийн үүргийг ухамсартайгаар гүйцэтгэх нь зүйтэй.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ЭРХ	САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ТАНЫ ҮҮРЭГ
- СҮҮ байгууллага, тэдгээрийн ажилтан, албан хаагчид, төлөөлөгчдөөс эрх тэгш, ёс зүйтэй харьцахыг шаардах,	- Хэрэглэгч бүртэй эрх тэгш, шударга харилцах мэргэжлийн ёс зүйтэй байх,
-Санхүүгийн байгууллагад өгсөн мэдээллийнхээ нууцлалыг хадгалуулах, бусдад задруулахгүй байхыг шаардах,	-Хэрэглэгчийн санхүүгийн болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах,
- Үнэн зөв, тодорхой, цаг үеэ олсон мэдээллийг авах,	-Хэрэглэгч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох,
- Санхүүгийн байгууллагын ажилтны харьцаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар гомдол, санал гаргах,	- Хэрэглэгчийн гомдлыг үр дүнтэй, хурдан шуурхай, санхүүгийн чирэгдэлгүй барагдуулах дотоод тогтолцоотой байх,
- Өөрийн дансны гүйлгээ болон аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тогтмол авах,	- Хэрэглэгчийг санхүүгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллээр бүрэн хангах,
- Таны худалдан авсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд шинээр хүү, шимтгэл, суутгал нэмэгдэх, хураамжид өөрчлөлт орох тохиолдолд урьдчилан мэдэх,	- Хэрэглэгч бүрийг мэдээллийн нээлттэй, ил тод байдлаар хангах,

САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ТАНЫ ЭРХ	САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧ ТАНЫ ҮҮРЭГ
<p>- Гэрээний нөхцөл, заалтыг цаг тухайд нь биелүүлэхийг хэрэглэгчээс шаардах,</p>	<p>- СҮҮ-тэй байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрийн бүх зүйл заалт, нөхцөлийг анхааралтай унших, өөрт ойлгомжгүй зүйлийг лавлаж тодруулах, гэрээний бүх зүйл заалтыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гарын үсэг зурж баталгаажуулах;</p>
<p>- Хэрэглэгчээс үнэн зөв мэдээлэл, бичиг баримтыг гаргуулах,</p>	<p>-СҮҮ-тэй аливаа гэрээ, хэлэлцээр байгуулахын өмнө болон хойно аль ч үед өөрийн санхүүгийн нөхцөл байдал, хүндрэлийн талаар мэдэгдэх, СҮҮ-ийг төөрөгдөлд оруулахуйц худал хуурмаг, бодит бус, дутуу мэдээллээр хангахгүй байх,</p>
<p>- Бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах,</p>	<p>СҮҮ-ээс авсан аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллээ бусдад задруулахгүй байж аюулгүй байдлаа бүрэн хангах арга хэмжээ авах,</p>
<p>- Хэрэглэгчийн санхүүгийн нөхцөл байдал, орлого/ зарлагын хэмжээ, нийгмийн статусын талаарх мэдээллээр бүрэн хангагдах.</p>	<p>- Танай хувийн (гэр бүлийн байдал, хаяг, утасны дугаар г.м) болон санхүүгийн (цалин орлого) нөхцөл байдалд орсон аливаа өөрчлөлтийн талаар СҮҮ-дээ мэдэгдэх.</p>

Санхүүгийн луйвар залилан, хуурамч сайтаас өөрийгөө хамгаалах



Луйварчид бараг хүн бүрийг бай болгосон байдаг. Зарим луйвар, заль мэхийг олж танихад хялбар байдаг бол заримыг илрүүлэхэд хэцүү байдаг.

Санхүүгийн залилан, луйврын хохирогч болсноор хүмүүс их хэмжээний мөнгөө алдаж, асар их сэтгэл санааны дарамтад ордог. Дараах зөвлөмж нь таныг болон таны гэр бүлийг луйварчид, хууран мэхлэгчдийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, зайлсхийхэд тусална.

Карт, нууц үг, нууц (PIN) кодоо найдвартай хадгалах



Хэн нэгэн танд туслах дүр эсгэн, АТМ-с мөнгийг тань авч өгье гэж санал болгоход нь та тэр хүнд карт болон нууц кодоо өгвөл тэр хүн таны данснаас мөнгө аваад танд өгөлгүй, өөрөө ашиглаж болох юм.

Компьютерээ хамгаалагдсан эсэхийг шалгах



Вирус болон “spyware”-г олж илрүүлэн устгахын тулд эдгээрээс хамгаалах програм (жишээ нь, “anti-virus” ба “anti-spyware”) болон “firewall” хамгааллыг байнга шинэчлэх буюу “update” хийх хэрэгтэй.

Хялбар таахааргүй нууц үг сонгон ашиглах замаар компьютерээ хамгаалах хэрэгтэй. Таныг ашиглаагүй үед компьютерын дэлгэц цоожлогдож, нууц үг шаардахаар тохируулга хийгээрэй. Үсэг, тоо хольж ашигласан таахад хэцүү нууц үгийг хэрэглээрэй.

Тогтмол ашигладаг цахим хуудас, жишээ нь, таны харилцагч банкны болон тогтмол худалдан авалт хийдэг дэлгүүрийн цахим хуудсыг “bookmark” хийн хадгалж, тэдгээрийн нэрийг шууд бичих, эсвэл хадгалсан линкүүдийг шууд ашиглаж байгаарай. Хэдийгээр жинхэнэ мэт санагдавч хуурамч сайт байж болзошгүй учраас цахилгаан шуудангаар танд илгээсэн цахим хуудасруу битгий хандаарай.

Өөрийнхөө онлайн ашигладаг нууц үгийг өөр хэнд ч хэлж болохгүй. Банкууд нууц үгийг бүтнээр нь асуудаггүй, ихэвчлэн таны нууц үгээс үсэг сонгож асуудаг. Хэрэв хэн нэгэн танруу утасдаж таны нууц үгийг бүтнээр нь асуувал энэ нь хуурамч этгээд байж болох тул хэлж болохгүй. Банкны ажилтан хэзээ ч танруу утасдаж таны нууц код, эсвэл CVV кодыг (картын ард байрлах 3 оронтой код) асуухгүй.

Онлайн худалдан авалтыг нийтээр ашигладаг компьютер ашиглан хийж хэрхэвч болохгүй. Ийм компьютерүүд вирус, эсвэл “spyware”-тай байх нь элбэг.

АТМ-тэйгээ сайн танилцах



Өөрийн тогтмол ашигладаг АТМ-үүдээ сайн мэдэж байх хэрэгтэй. Ингэснээр хулгайч таны карт болон хувь хүний мэдээллийг хулгайлах төхөөрөмжийг АТМ-д суурилуулсан байвал машинд гарсан өөрчлөлтийг та анзаарч чадна. Сэрэмжлүүлэг санамж байршуулсан АТМ-ийг битгий ашиглаарай. Тэд гадны хуурамч этгээдийн дайралтанд өртсөн байж болзошгүй.

Хэрэв АТМ таны картыг “залгиад” эргэж гаргаж ирэхгүй бол, эсвэл, та картаа алга болгосон бол бусад хүн таны картыг ашиглахаас сэргийлж харилцагч банкиндаа тэр даруй мэдэгдэх хэрэгтэй. Хулгайлагдсан болон алга болгосон картын талаар банкиндаа мэдэгдэхийн тулд та картын ард бичигдсэн утасны дугаарыг тэмдэглэж хадгалах нь зүйтэй.

Онлайн худалдан авалт хийхдээ болгоомжтой байх



Ямар нэг зүйл онлайн аар худалдан авч байгаа бол тухайн цахим хуудас аюулгүй, найдвартай эсэхийг шалгаарай. Зөвхөн <https://> гэж эхэлсэн цахим хуудсанд л картынхаа мэдээллийг оруулж болно. <http://> гэж эхэлсэн цахим хаяг найдваргүйд тооцогддог. “secure” буюу аюулгүй, найдвартай

цахим хаяг болохыг “s” тодорхойлох учраас заавал <https://> байх ёстойг санах хэрэгтэй. Түүнчлэн найдвартай, аюулгүй цахим хаягийн өмнө цоожны зураг байх ёстой.

Хувийн мэдээллээ найдвартай хадгалах



Хэрэв та хувийн дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан баримт бичгийг устгах гэж байгаа бол (жишээ нь, кредит картын мэдээлэл бүхий баримт) хогийн саванд хийхээсээ өмнө шатаах, эсвэл баримт бичиг устгадаг машинаар жижиглэн устгах хэрэгтэй.

- ✓ Танд хэрэгтэй бүх баримт бичгийг найдвартай газарт хадгалаарай.
- ✓ Дебит болон зээлийн эрхтэй кредит картуудаа найдвартай газарт хадгалаарай.

Банкны хуулгаа шалгах

Танд илгээсэн банкны хуулга, кредит картын гүйлгээний тайлан тус бүрийг сайн шалгаж, таны хийсэн, гүйлгээ, орлого зарлага мөн эсэхийг хянаарай. Үүнийг шалгахын тулд та өөрөө орлого, зарлагаа тооцож тэмдэглэл хөтөлдөг байх нь зүйтэй. Тухайн банкны хуулга алдаатай мэт санагдах, эсвэл банкны зарим суутгал шимтгэлийг ойлгохгүй байгаа бол нэн даруй харилцагч банкиндаа хандаж, тодруулаарай.

Хуулга алдаатай бол банк тухайн алдааг гаргасан гэсэн үг. Гэвч заримдаа луйвар, залилангийн үйл ажиллагааны улмаас ийм зүйл тохиолдох нь бий. Иймд банкны хуулга, кредит картын гүйлгээний тайлангаа хойшлуулалгүй шалгаж байх нь чухал. Хэрэв та өөрийгөө луйвар, залилангийн хохирогч болсон гэж үзэж байвал харилцагч банкиндаа нэн даруй мэдэгдсэнээр банк таныг нэмж мөнгө алдахаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авахад тусална.

Нийтлэг залилан, луйвар

Залилан мэхлэгчид арга барилаа тогтмол өөрчилдөг. Иймд ямагт анхаарал сэрэмжтэй байх нь чухал.

САНАМЖ

**ҮНЭМШИХЭД ХЭЦҮҮ ТӨГС ТӨГӨЛДӨР СОНСОГДООД БАЙВАЛ
ЭНЭ НЬ БАРАГ Л ХУДАЛ ГЭСЭН ҮГ!**



**ХЭРЭВ ТА ЛУЙВАР ЗАЛИЛАНГИЙН ХОХИРОГЧ
БОЛСОН БОЛ ЮУ ХИЙХ ВЭ?**

ХЭРЭВ САНХҮҮГИЙН ЛУЙВАР, ЗАЛИЛАНГИЙН ХОХИРОГЧ БОЛСОН БОЛ ЭНЭ ТУХАЙ МЭДЭЭЛЭХ

Хэрэв та санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болсон бол санаа зовох хэрэггүй. Энэ тухайгаа холбогдох газар мэдээлэх хэрэгтэй. Ийнхүү мэдээлснээр, та өөрийнхөө хохирлыг бүрэн, эсвэл зарим хэсгийг эргүүлэн олж авах болон бусад хүмүүсийг ижил төрлийн санхүүгийн луйвар, залилангийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд тусална.

5. ЗЭЭЛ, ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ



Асуулт 1. Зээлийн гэрээ гэж юу вэ?

Банкууд зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг нийтэд санал болгож мэдээлдэг. Зээлийн гэрээг бичгээр байгуулах ба мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээдэг.

Асуулт 2. Гэрээнд гарын үсэг зурахдаа юуг анхаарах вэ?



Зээлдэгч нь гэрээнд гарын үсэг зурахаас өмнө гэрээг сайн унших хэрэгтэй ба ойлгохгүй зүйл заалт байвал банкны ажилтнаар сайтар тайлбарлуулах хэрэгтэй. Ямар ч үед яаран сандран гарын үсэг зурж болохгүй. Нөгөө талаас банкууд харилцагчдад хугацаа өгч зээлийн гэрээтэй сайтар танилцах боломжийг өгч байх ёстой. Нэгэнт гэрээнд гарын үсэг зурж зээл авсан бол тэр гэрээ нь хүчин төгөлдөр болно гэсэн үг юм. Монголбанк ч талууд харилцан тохиролцон

байгуулсан гэрээг өөрчлөх эрх байхгүй. Иймд банк ч тэр зээлдэгч ч мөн адил өөрийн санхүүгийн зан байдал, орлого, эргэн төлөх хуваарь, хугацаа зэргийг сайн тооцох хэрэгтэй. Зарим тохиолдол зээл олгохгүй байх нь зээлдэгчийн төлөө шийдвэр ч байж болно.

Асуулт 3. Гэрээний гол нөхцөлүүд юу байх ёстой вэ?

Ямар ч гэрээнд гэрээний хугацаа, хүү, нэмэгдүүлсэн хүү тооцох болон зээлийн эргэн төлөлт, зээлийн хугацаа хэтрүүлбэл хүлээх хариуцлага, барьцаа хөрөнгөөр зээл, хүү, нэмэгдүүлсэн хүү болон бусад зардлыг багтаан төлүүлэх асуудал заавал тусгагддаг.

Асуулт 4. Зээл хугацаандаа төлөхгүй байх болон төлж чадахгүй бол яах вэ?

Энд хэд хэдэн үр дагавар үүсдэг. Санхүүгийн болон амьдралын хэвийн нөхцөл алдагдана. Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй байдаг. Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлнэ. Мөн хөдлөх эд хөрөнгөнд үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй байдаг.

Зээлийн мэдээллийн санд буюу тухайн хүний зээлийн түүхэнд тэмдэглэгдэн үлдэнэ.

Асуулт 5. Зээлийн мэдээллийн санд бүртгэгдэнэ гэж юу гэсэн үг вэ?

Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээл олгогч байгууллага зээлдэгчийн мэдээллийг түүний зөвшөөрөлтэйгээр Зээлийн мэдээллийн санд нийлүүлэх үүргийг хүлээсэн байдаг. Зөвшөөрөлтэйгээр гэдэг нь зээлийн гэрээнд заавал тусгагддаг заалт бөгөөд энийг зээлдэгч нар төдийлөн анзаардаггүй. Ерөнхийдөө зээлийн мэдээллийн сан гэдэг нь зээлдэгч гэрээний үүргээ тухай бүр биелүүлсэн тохиолдолд банк санхүүгийн байгууллага найвдартай зээлдэгч байна гэж үзэн зээлийн хэмжээ өндөр, хүү бага, урт хугацааны зээл олгох шийдвэр гаргахад нөлөөлдөг. Харин үүргээ биелүүлдэггүй зээлдэгчийн мэдээллийг бүртгэснээр банк эрсдэлтэй зээлдэгч гэж үзэн зээл олгохгүй байх шийдвэр гаргах магадлалтай болдог. Гэхдээ энэ нь огт зээл олгохгүй гэсэн үндэслэл биш бөгөөд тухай банк, зээл олгож буй газрын харилцагчаа үнэлэхэд л ашиглагдаж буй мэдээлэл юм.

Зээлийн мэдээллийн санд мэдээлэл бүртгэгдэнэ гэдэг бол тухайн хүний зээлийн түүхийн мэдээлэл бөгөөд зээл авч байсан байдал, хугацаандаа төлсөн

бол хэвийн төлөгдсөн, хэрэв хугацаа хэтэрсэн бол зээлийн ангилалаар мэдээлэл нь бүртгэгддэг. Зээлийн ангилал нь хэвийн, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, муу гэж хуваагддаг.

Асуулт 6. Хадгаламж барьцаалсан зээл авах хүсэлтэй байгаа бол иргэн та юуг анхаарах ёстой вэ?

Танд богино хугацааны мөнгөний хэрэгцээ гарах үед өөрийн хугацаатай хадгаламжаа барьцаалан ямар нэгэн бичиг баримт бүрдүүлэхгүйгээр хүссэн газраасаа хүссэн бакнаасаа зээл авах боломжтой. Энэ нь таны санхүүгийн хэрэгцээг богино хугацаанд шийдвэрлэх мөн хугацаатай мөнгөн хадгаламжийн хүүгээ цуцлахгүй бөгөөд, хуримтлагдсан хүү хугацааг алдагдуулахгүйгээр зээлийг бүх төрлийн валютаар авах боломжтой юм.

Зээл авахын өмнө та банкнаас тавьж буй доорх нийтлэг шаардлагуудыг мэдсэн байвал зохино. Үүнд:

- ✓ **Хэмжээ:** Банкны тухайн үед мөрдөж буй зээл /ҮХШЕН/-ийн нөхцөл үйлчилнэ,
- ✓ **Хугацаа:** Хугацаатай хадгаламжийн дуусах хугацаанаас хамаарч, 1 жил хүртэл хугацаагаар олгоно.
- ✓ **Зээлийнхүү:** Банкны тухайн үед мөрдөж буй Зээл/ҮХШЕН/-ийн нөхцөл үйлчилнэ.

Хадгаламж барьцаалсан онлайн зээлийг харилцагч өөрийн цахим банкны эрхээр хандаж авах ба хадгаламж барьцаалсан онлайн зээлийн гэрээ байгуулагдсан гэж үздэг.

Зээлийн хугацаа дуусах өдөр зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлөөгүй тохиолдолд, тухайн банкин дах мөнгөн хадгаламжийн данс болон бусад данснаас зээлийн төлбөр болон бусад төлбөрийг үлмаргахжурмаарсуутганавдаг тул иргэн та өөрийн хадгаламжаа барьцаалж зээл авах тохиолдолд гэрээтэйгээ сайтар уншиж танилцаж, гэрээнийхээ нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэрээгээ хийгээрэй.

Хадгаламж барьцаалсан зээл нь зээлдэгчийн төлбөрөөс тэргүүн ээлжинд зээлийн хүүг тооцон хасч, үлдсэнийг үндсэн зээлийн төлбөрт суутгах зарчим баримталдаг. Хэрэв Зээлдэгч Гэрээнд заасан хугацаанд зээлийн төлбөрийг барагдуулалгүй, хугацаа хэтэрч нэмэгдүүлсэн хүү төлөх тохиолдолд нэмэгдүүлсэн хүүг эхэлж төлүүлдэг. Иймд та зээлийн гэрээг хариуцлагатайгаар уншиж танилцаад банкнаас тавьж буй нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэрээ хийхийг дахин анхаарна уу.

Асуулт 7. Орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдах хүсэлтэй байгаа бол иргэн та юуг анхаарах ёстой вэ?

Орон сууц худалдан авах нь хүний амьдралд цөөхөн тохиолдох хөрөнгө оруулалтын чухал шийдвэрийн нэг билээ. Хэрэв та орон сууцаа банкны зээлээр худалдан авахаар шийдсэн бол дараах бяцхан зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- ✓ Орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдах хүсэлтэй иргэн та худалдан авах гэж буй орон сууцны үнийн дүнгийн тодорхой хэмжээний урьдчилгаа төлбөрийг өөрөө бүрдүүлсэн байх шаардлагатай.
- ✓ Иргэн та урт хугацаанд зээлээ хэвийн төлөөд явахад хангалттай тогтмол орлоготой байх шаардлагатай. Орон сууцны ипотекийн зээл нь урт хугацаатай байдаг тул урт хугацааны турш зээлээ доголдолгүй төлөөд байх тогтвор суурьшилтай ажилтай, орлогын эх үүсвэртэй байх хэрэгтэй. Мөн зээлийн төлбөр нь өндөр байвал айл өрх амьдралын бусад зардлаа төлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй тул зээлийн сарын төлбөр нь өрхийн сарын төлбөрт тодорхой хэмжээний хязгаарлалт тавьдаг.
- ✓ Банкны зээлийн эдийн засагчаас мэргэжлийн зөвлөгөө авч, өөрт тохирсон зээлийг сонгох хэрэгтэй. Банкны зээлийн мэргэжилтнээс зээлийн хүү, хугацаа, зээлийн төлбөрийг бодох аргачлал, зээлийн сарын төлбөрийн хэмжээ, зээлийн хугацааны турш зээлийн хүүд төлөх дүн зэрэг зээлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг авч бусад банк, санхүүгийн байгууллагын орон сууцны бүтээгдэхүүнтэй харьцуулж үзэх нь зүйтэй байдаг.
- ✓ Орон сууцны зээлэнд хамрагдахад зээлийн сарын төлбөрөөс гадна зээлийн баримт бичиг бүрдүүлэхэд гарах зардлаас авахуулаад банкны зээлийн шимтгэл, зээлийн даатгалын хураамжтай холбоотой багагүй зардал гардаг болохыг сайтар бодолцон үзэж, мэргэжлийн зөвлөгөө авсаны үндсэн дээр шийдвэрээ гаргаарай.
- ✓ Түүнчлэн даатгалын бүтээгдэхүүнийг сайтар судалж, өөрийн хэрэгцээ шаардлагад тохирсон бүтээгдэхүүнийг сонгож даатгуулснаар ирээдүйд гарах аливаа эрсдэлээс өөрийгөө болоод гэр бүлээ хамгаалж чадах юм.

Доорх гурван хүснэгтээр 10, 15, 20 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн хүүтэй, 40, 50, 60 сая төгрөгийн орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдахад төлөх сарын тэнцүү төлбөрийг харьцуулж үзвэл:

10 жил буюу 120 сар						
Зээлийн хэмжээ	Зээлийн хүү / жил/	Зээлийн хүү /сар/	Нэг сард төлөх зээлийн төлбөр	Нэг жилд төлөх зээлийн төлбөр	Нийт зээлийн төлбөр	Нийт хүүний төлбөр
40 000 000,00	8,00%	0,6667%	485 310,38	5 823 724,53	58 237 245,29	18 237 245,29
50 000 000,00	8,00%	0,6667%	606 637,97	7 279 655,66	72 796 556,61	22 796 556,61
60 000 000,00	8,00%	0,6667%	727 965,57	8 735 586,79	87 355 867,94	27 355 867,94
15 жил буюу 180 сар						
Зээлийн хэмжээ	Зээлийн хүү / жил/	Зээлийн хүү /сар/	Нэг сард төлөх зээлийн төлбөр	Нэг жилд төлөх зээлийн төлбөр	Нийт зээлийн төлбөр	Нийт хүүний төлбөр
40 000 000,00	8,00%	0,6667%	382 260,83	4 587 130,00	68 806 950,07	28 806 950,07
50 000 000,00	8,00%	0,6667%	477 826,04	5 733 912,51	86 008 687,59	36 008 687,59
60 000 000,00	8,00%	0,6667%	573 391,25	6 880 695,01	103 210 425,11	43 210 425,11
20 жил буюу 240 сар						
Зээлийн хэмжээ	Зээлийн хүү / жил/	Зээлийн хүү /сар/	Нэг сард төлөх зээлийн төлбөр	Нэг жилд төлөх зээлийн төлбөр	Нийт зээлийн төлбөр	Нийт хүүний төлбөр
40 000 000,00	8,00%	0,6667%	334 576,03	4 014 912,33	80 298 246,62	40 298 246,62
50 000 000,00	8,00%	0,6667%	418 220,03	5 018 640,41	100 372 808,28	50 372 808,28
60 000 000,00	8,00%	0,6667%	501 864,04	6 022 368,50	120 447 369,94	60 447 369,94

6. ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Зээлийн мэдээлэл гэж юу вэ?

Зээлдүүлэгчийн өмнө хууль, гэрээгээр хүлээсэн зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх мэдээлэл

Зээлийн мэдээллийн сан:

Монголбанк болон зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн эзэмшиж буй зээлдэгчийн зээлийн мэдээлэл

Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч:

- ✓ Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо;
- ✓ Санхүүгийн түрээсийн компани;
- ✓ Төрийн байгууллага /эд хөрөнгийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон татвар, нийгмийн даатгал, гааль, эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх/
- ✓ Үүрэн холбооны операторууд
- ✓ Гэрээний дагуу бусад хуулийн этгээдүүд

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг хэрхэн ангилдаг вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилна. Өр төлбөр төлөгдөх хугацаанаас хэтэрсэн хоногоор:

- ✓ Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт 15 хүртэл хоног -**Хэвийн**
- ✓ 90 хүртэл хоног-**Анхаарал хандуулах**
- ✓ 91-180 хоног -**Хэвийн бус**
- ✓ 181-360 хоног -**Эргэлзээтэй**
- ✓ 361-с дээш хоног -**Муу**

Зээлээ хугацаа хэтрүүлж төлсөн, зээлийн муу түүхтэй зээлдэгчид зээл олгохгүй гэсэн хууль, журам байдаг уу?

Байхгүй. Тухайн зээл олгогч байгууллага зээлдэгчийн өмнө болон одоогийн санхүүгийн чадамж, санхүүгийн эрсдлийг тооцож, зээл олгох эсэх шийдвэрийг бие даан гаргана.

7. ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ЗЭЭЛЭНД ХАМРАГДАХ

Орон сууц худалдан авах нь хүний амьдралд цөөхөн тохиолдох хөрөнгө оруулалтын чухал шийдвэрийн нэг билээ. Хэрэв та орон сууцаа банкны зээлээр худалдан авахаар шийдсэн бол дараах бяцхан зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

- ✓ Орон сууцны ипотекийн зээлэнд хамрагдах хүсэлтэй иргэн та худалдан авах гэж буй орон сууцны үнийн дүнгийн тодорхой хэмжээний урьдчилгаа төлбөрийг өөрөө бүрдүүлсэн байх шаардлагатай.
- ✓ Иргэн та урт хугацаанд зээлээ хэвийн төлөөд явахад хангалттай тогтмол орлоготой байх шаардлагатай. Орон сууцны ипотекийн зээл нь урт хугацаатай байдаг тул урт хугацааны турш зээлээ доголдолгүй төлөөд байх тогтвор суурьшилтай ажилтай, орлогын эх үүсвэртэй байх хэрэгтэй. Мөн зээлийн төлбөр нь өндөр байвал айл өрх амьдралын бусад зардлаа төлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй тул зээлийн сарын төлбөр нь өрхийн сарын төлбөрт тодорхой хэмжээний хязгаарлалт тавьдаг.
- ✓ Банкны зээлийн эдийн засагчаас мэргэжлийн зөвлөгөө авч, өөрт тохирсон зээлийг сонгох хэрэгтэй. Банкны зээлийн мэргэжилтнээс зээлийн хүү, хугацаа, зээлийн төлбөрийг бодох аргачлал, зээлийн сарын төлбөрийн хэмжээ, зээлийн хугацааны турш зээлийн хүүд төлөх дүн зэрэг зээлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг авч бусад банк, санхүүгийн байгууллагын орон сууцны бүтээгдэхүүнтэй харьцуулж үзэх нь зүйтэй байдаг.
- ✓ Орон сууцны зээлэнд хамрагдахад зээлийн сарын төлбөрөөс гадна зээлийн баримт бичиг бүрдүүлэхэд гарах зардлаас авахуулаад банкны зээлийн шимтгэл, зээлийн даатгалын хураамжтай холбоотой багагүй зардал гардаг болохыг сайтар бодолцон үзэж, мэргэжлийн зөвлөгөө авсаны үндсэн дээр шийдвэрээ гаргаарай.
- ✓ Түүнчлэн даатгалын бүтээгдэхүүнийг сайтар судалж, өөрийн хэрэгцээ шаардлагад тохирсон бүтээгдэхүүнийг сонгож даатгуулснаар ирээдүйд гарах аливаа эрсдэлээс өөрийгөө болоод гэр бүлээ хамгаалж чадах юм.

8. ДААТГАГДСАН ХАДГАЛАМЖ, ХАМГААЛАГДСАН ХУРИМТЛАЛ

Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой үүсгэн байгуулагдсан Хадгаламжийн даатгалын корпораци нь таны банкин дахь харилцах, хадгаламжийн 20 сая хүртэлх төгрөгийг даатгаж, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа явуулдаг.

Хадгаламжийн даатгалын тогтолцоо гэж юу вэ?

Банк дампуурсан тохиолдолд Хадгаламжийн даатгалын сангаас таны тухайн банкин дахь харилцах хадгаламжийн дансан дахь нийт 20 сая хүртэлх төгрөгийн нөхөн олгох үйл ажиллагааг хэлнэ.

Хадгаламжийн даатгалын тогтолцоо ач холбогдол

- ✓ Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах
- ✓ Иргэдийн банкинд итгэх итгэлийг бэхжүүлэх
- ✓ Хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах

Даатгалд хэн хамрагдах вэ?

Банкинд төгрөг болог валютын харилцах, хадгаламжийн данстай иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүр даатгалд хамрагдана.

Даатгалд хэрхэн хамрагдах вэ?

Хадгаламжийн даатгалд хамрагдахын тулд иргэн та ямар нэгэн төлбөр хураамж төлөх шаардлагагүй ба зөвхөн харилцагч банк тань хуульд заасны дагуу хадгаламжийн даатгалын хураамжийг харилцагчдынхаа өмнөөс төлдөг. Ингэснээр хадгаламж эзэмшигч та даатгалд хамрагдана.

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тодорхойлох вэ?

Хадгаламж эзэмшигчийн хадгаламжийн дүн болон хуримтлагдсан хүүгийн дүнг банкны дампуурлыг албан ёсоор зарласан өдрийн байдлаар нэгтгэж, тухайн банкинд төлбөл зохих зээл хүүгийн хамт хасч тодорхойлно.

Зээлдэгч зээлийн лавлагааг хаанаас авах вэ?

Өөрийн харилцдаг банкныхаа төв салбарын зээлийн мэдээлэл хариуцсан ажилтнаас лавлах боломжтой.

БАНКНЫ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН АЖИЛТНЫ УТАСНЫ ЖАГСААЛТ

Д/д	Банкны нэр	Утасны дугаар
1	Капитал банк	70001912-106
2	Худалдаа хөгжлийн банк	331245
3	Хаан банк	332333-3061
4	Голомт банк	75751111-1221
5	Ариг банк	70122222, 344550-127
6	Тээвэр хөгжлийн банк	99994992
7	Улаанбаатар хотын банк	319041-313
8	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	75757070-1018
9	Капитрон банк	327383
10	Хас банк	75771888-812
11	Чингис хаан банк	318367
12	Төрийн банк	310103
13	Кредит банк	319038-123
14	Богд банк	7577 1199 -1019

*Үүрэн телефоны оператор компанитай холбоотой зээлийн мэдээллийн санд орсон мэдээллийг дараах утсаар холбогдож авах боломжтой.

Д/д	Үүрэн телефоны оператор байгууллага	Утасны дугаар
1	Юнител ХХК	777118811
2	Скайтел ХХК	91120202-3031
3	Мобиком корпораци ХХК	75759944-7044
4	Жи-мобайл ХХК	98106000



**САНХҮҮГИЙН
ХЭРЭГЛЭГЧИЙГ
ХАМГААЛАХ АЯН**

2018 01.02-05.31



www.mongolbank.mn



[@mongolbank.mn](https://www.facebook.com/mongolbank.mn)



[@mongolbank.mn](https://www.twitter.com/mongolbank.mn)



[mongolbank](https://www.youtube.com/mongolbank)

Холбоо барих утас: 328298